

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2021 оны 12 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Арваннхоёрдугаар сард 381 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 55 12 дугаар ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна. Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 187 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Нийт ирүүлсэн өргөдөл 28, үүнээс ажлын байр хүссэн-3, бусад-25 байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2021 оны 12 дугаар сарын байдлаар шинээр төрсөн -134, үүнээс эрэгтэй – 73, эмэгтэй-61, үрчилсний бүртгэл – 4 үүнээс: эр 2, эм-2, овог, нэр өөрчилсний бүртгэл-6, үүнээс: эр -2, эм-4, эцэг тогтоосны бүртгэл -6 үүнээс: эр -2, эм-4, гэрлэсний бүртгэл -16, нас баралт-56 /эрэгтэй-32, эмэгтэй -24/ тус тус байна.

Иргэний үнэмлэх:

Цахим иргэний үнэмлэх шинээр захиалсан-47, үүнээс эр-27, эм-20, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 128, үүнээс эр-71, эм-47, аймаг, нийслэлээс – 7 насанд хүрэгч, 4 хүүхэд, сум, дүүргээс -22 насанд хүрэгч, 13 хүүхэд баг хооронд- 4 насанд хүрэгч, 6 хүүхэд шилжин ирж бүртгэгдсэн байна.

Төсөв санхүүгийн талаар.

Жилийн эцсийн ажил дуусч төсөв байгууллагуудын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу өр авлагыг барагдуулж гүйлгээг цаг хугацаанд нь түргэн шуурхай хийж гүйцэтгэлээ. Орон нутгийн татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл.

Нийт орлого	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
➤ Татварын орлого	93340,0	155923,2	167,0%
➤ Татварын бус орлого	85000,0	47426,8	55,8%

Хөрөнгө оруулалт.

Улсын төсвийн хөрөнгөөр 2693,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнд:

- Дотуур байр 1,200,0 сая төгрөг
- Дотуур байрын тоног төхөөрөмж 40,0 сая төгрөг
- Соёлын төвийн барилга 1403,0 сая төгрөг
- Угаалгийн ванн 45,0 сая төгрөг
- Бод малын үзлэгангилалтын зогсоол 5,0 сая төгрөг

**ОНХСАНГААР ХИЙГДСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨӨ ГҮЙЦЭТГЭЛ**

Хийгдэх ажил	он	Төлөвлөгөө	2021 оны гүйцэтгэл	Үлдэгдэл	Гүйцэтгэгч байгууллага
Гэр цэцэрлэг нэмэгдүүлэх	2020 - 2021	20,000,000.0 0	19,650,000.0 0	350,000.00	Хүрэл соёмбо ХХК
ЕБС-ийн мэдээлэл зүйн кабинет дутуу	2020 - 2021	8,978,000.00	8,978,000.00	-	
Нийтийн халуун усны барилга	2021	90,000,000.0 0		90,000,000.0 0	
Чийрэгжүүлэлт ийн төв	2021	35,000,000.0 0	30,000,000.0 0	5,000,000.00	Санаа мед трейд ХХК
Ухаалаг худгийн төхөөрөмж	2021	9,100,000.00	9,000,000.00	100,000.00	Баялаг говь ХХК
Цамхаг гэрэл	2021	9,200,000.00	9,200,000.00	-	Түмт сэтгэхүй ХХК
Газар чөлөөлөлт	2021	46,165,700.0 0	45,000,000.0 0	1,165,700.00	Д.Сарантуяа. Д.Наранхүү П.Цэцгээ, П.Бурмаа
Зураг төсвийн үнэ	2021	29,000,000.0 0	26,800,000.0 0	2,200,000.00	Ти эл прожект ХХК
Жишиг хорооллын 04 квт-ын ЦДАШ өргөтгөл	2021	10,000,000.0 0	10,000,000.0 0	-	Ампер ХХК
Өвөлжилтийн бэлтгэлийг хангах	2021	20,000,000.0 0	20,000,000.0 0	-	Хан бүргэд ХХК
Угаалгын ванн	2021	20,000,000.0 0		20,000,000.0 0	
Дүн		297,443,700. 00	178,628,000. 00	118,815,700. 00	

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 8 дугаар хуралдаанаар 2020 оны төсвийн гүйцэтгэл, 2022 оны төсвийн төслийг хийж хуралд орууллаа.

Сумын 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1403137,5 мянган төгрөг буюу дор дурдсанаар баталлаа. Үүнд

1. Сумын татварын болон татварын бус орлого 345394,5 мянган төгрөг
2. Сумын төсөвт Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 545626,0 мянган төгрөг
3. Сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 329199,5 мянган төгрөг
4. Сумын төсвийн урьд оны үлдэгдэл 162417,5 мянган төгрөг
 - Төрийн сангийн үлдэгдэл 40810,3 мянган төгрөг
 - ОНХСангийн үлдэгдэл 111607,2 мянган төгрөг
 - Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 10000,0 мянган төгрөг
5. Сумын төсвийн тухайн жилийн төсвийн байгууллагын өөрийн орлого 20500,0 мянган төгрөг
 - Сумын ЗДТГазар 500,0
 - СХСангийн орлого-20000,0

2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1403137,5 мянган төгрөгөөр баталж Төсвийн ерөнхийлөн захирагчид хүлээлгэн өглөө.

Статистик мэдээлэл Сумын хэмжээнд 2021 оны жилийн эцэст 897 өрх, 2901 хүн ам, үүнээс малчин өрх 704 тоологдсон байна.

Мал тооллогоор нийт-271944 толгой мал тоолуулж, Үүнд:

- 1.Тэмээ-758,
- 2.Адуу-20403
- 3.Үхэр-16274
- 4.Хонь-147435
- 5.Ямаа-87074

6.123963 тус тус тоологдсон байна. Урьд оныхоос 4 төрөл дээр 12552 толгойгоор өссөн, үүнээс тэмээ-9 толгойгоор ухарсан. Нийт худаг-138, үүнээс инженерийн хийцтэй худаг-81, энгийн уурхай-57 тус тус тооллогдож дүнг аймгийн статистикийн хэлтэст хүлээлгэн өглөө.

Бусад ажлын хүрээнд

Монгол Улсад Санхүүгийн алба үүсч хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан ХАЙР ДҮҮРЭН БОГЦ аянд нэгдэж 5 хүүхдэд бэлгийг олгон сумандаа баярын арга хэмжээ зохион байгуулан олон жил тогтвор сууршилтай ажилласан хүмүүсээ шагнаж урамшууллаа.

Татварын чиглэлээр:

2021 оны ИТХ-р тогтоосон тогтоолын дагуу МТТАТ –н хураалт багийн Засаг дадарга нартай хамтарч 11,12 саруудад хураагдсан. 12 сарын 23-ны өдрийн байдлаар

Малын тоо толгойн албан татварыг нийт 63,830,600 төгрөг буюу 81,7%-тай сумын төрийн сангийн дансанд хуримтлуулаад байна.

МТТАТ хураалттай холбоотой нийт малчдын татвар төлсөн нь үнэн болох тайланг 2021.12.1-12.15 ны хооронд малчин тус бүрээр Етах-д холбот хийн тайлагнаж 708 тайлан хийгдэхээс 498 тайлан 70,3% тай хийгдэж дууссан. Ноолуурын урамшуулал олгосоны татварын тайлан 2020 оны хоцорсон тайланг 2021 онд 652 тайлан хийх хүсэлт илгээж байна.

Өөрийн нэр дээр байдаг ч зарсан, хамаатан садандаа шилжүүлсэн, эвдэрсэн машин техникээ хасалт хийлгээгүй 10 хүмүүст заавар зөвөлгөө өгч, 2 иргэнд тодорхойлолт хийж өгсөн. 2022 оны төсөв хэлцэж задаргаа хийн Засаг даргаар батлуулан Сүхбаатар аймаг Татварын хэлтэст өгсөн.

АА нэгжийн тайлан болон өрийн нэхэмжлэл шүүж, 20 ААН-н өрийн баримт хэвлэн холбогдох хүмүүст хүлээлгэн өгч өрийг эхнээс нь хийлгэж эхэлсэн байна.

Сайн малчин шагналд тодорхойлох ажлын хэсэгт татварын тодорхойлолт 2019, 2020, 2021 онуудад төлж байсан татварын мөнгөн дүнг шүүн холбогдох багын дарга нарт өгсөн.

Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс-с өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь хийж гүйцэтгэж байна.

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

Аймгийн ГХБХБГазрын даргын 2021.12.03-ны өдрийн 1/410 дугаар албан бичгээр 12 дугаар сарын 06-ны өдрөөс 09-ны өдрүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх удирдамж ирсэн. Тус удирдамжийн хүрээнд холбогдох материалуудыг бүрдүүлэн ажилласан.

2021 оны хүн ам, ХАА-н тооллого хийх ажлын явцад хяналт тавих аймгийн мэргэжлийн хяналтын даргаар ахлуулсан ажлын хэсэг ирж ажилласан. Тус ажлын хэсэг баян багийн 1-р хэсэгт хяналт тавихаар явахад газарчилж явсан.

Нэгжийн даргатай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжилтийг тайлагналтын ажил болон ГНС-ын тайлан хүлээлгэн өгөх ажлаар 2021.12.20-ны өдрөөс 2021.12.23-ны өдрийн хооронд аймгийн ГХБХБГазар дээр ажилласан. 2021 онд хийж гүйцэтгэсэн тайлангаа хамгаалан үнэлүүлж сумын Засаг даргын баярын бичгээр шагнуулсан.

Шинээр газар өмчлөх 28 өргөдөл ирсэнийг газрын цахим программ хангамжид бүртгэсэн.

Газрын цахим биржийн программ хангамжид “газар эзэмших эрхийн нээлттэй дуудлага худалдаа явуулах” зарыг байршуулсан. Тус дуудлага худалдаа 2021.12.27-ний өдөр цахимаар зохион байгуулна.

Байгаль орчны чиглэлээр:

Хог хаягдлын чиглэлээр:

Иргэдийн аюулгүй зорчих байдлыг хангах, халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор зам цэвэрлэгээний ажлыг зохион байгууллаа. Тус ажилд ААН байгууллага хамтран 4 км хүртэлх замыг заагдсан хуваарийн дагуу цэвэрлэлээ.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр:

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа 2021 оны 12 сарын 20-ны байдлаар.

Хүнсний нөөцийн мэдээг ХХААГ-т долоо хоногийн Даваа, гарагт хүргүүлдэг.

Бүтээгдэхүүний нэр	Нөөц
Гурил	22 тн
Гурилан бүтээгдэхүүн	420 ш
Будаа	720 кг
Хуурай/Шингэн сүү	160 ш
Өндөг	1190 ш
Ургамлын тос	307 ш
Төмс	200 кг
Хүнсний ногоо	100 кг
Элсэн чихэр	600 кг
Давс	230 кг
Савласан ус	250 ш

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц болон татан авалтын хомсдол үүсээгүй, тээвэрлэлт хэвийн явагдаж байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим, түргэн гэмтэж чанар байдлаа алдах, хүнсний бүтээгдэхүүнийг техникийн зохицуулалтад заагдсан горимд хадгалж байгаад хяналт тавин хоол хүнсээр, дамжих өвчин, хордлого, халдвараас урьдчилан сэргийлэх, зорилгоор мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, зөвлөгөөг тогтмол хүргэн хяналтын хуудсийг хөтлүүлэн ажиллаж байна.

1.2. Шатахуун түлшний нөөцийн хувьд хэвийн хомсдол үүсээгүй.

№	Байгууллагын нэр	А-80	А-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	9,5тн	6тн	4 тн
2	Үнэ	2450төг	2480төг	3030 төг

№	Байгууллагын нэр	А-80	А-92	ДЗ
1	“Дарь” ХХК	3,5тн	6,3тн	7,3 тн

2	Үнэ	2480 төг	2480 төг	3030 төг
---	-----	----------	----------	----------

1.3. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгааг 11-12 сартай харьцуулан харуулав.

№	Бүтээгдэхүүний нэр		2021 оны 11 сарын 20 байдлаар	2021 оны 12 сарын 24 ны байдлаар
1	гурил	Дорнод дээд	36000	36000
		УБ 1-р зэрэг	37000	38500
		Дорнод 2-р зэрэг	29500	29500
2	Цагаан будаа		3000-3500	3500
3	Шингэн сүү		3700	3800-4000
4	Хуурай сүү		6500-12500	6500-12500
5	Элсэн чихэр		3000-3500	3000-3500
6	Ургамлын тос		5800-6500	5800-6800
7	Өндөг		650-700	600-700
8	Төмс		1300-1500	1300-1500
9	Хүнсний ногоо	Сонгино	3000	3000-3500
		Байцаа	2500-3000	2500
		Лууван	2200	3500
		Сармис	2500	3000
10	Давс		1000-1500	1000-2800
11	Савласан ус		800-3500	900-4000

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний зохиомол үнийн хомсдол үүсээгүй байна

Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр:

2021 оны 12 дугаар сарын 21-ны өдөр Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналтын зөвлөлөөс 3 гишүүний бүрэлдэхүүнтэй 2019 он-6, 2020 оны 3, 2021 оны 1 зээлдэгч нарын зээл ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаа. Шалгалтын үр дүнд, зээлдэгчийн үйл ажиллагаа хэвийн, зориулалтын дагуу ашиглаж байсан. Зээлдэгч нараас шар бүсэд шилжсэнтэй холбоотойгоор орлоготой, үйлчлэгч олонтой байгаа талаар дурдсан.

Мал, эмнэлгийн чиглэлээр:

2021 оны 11 сарын 29 нд аймгийн Мал эмнэлгийн газарт мал мах нэгдсэн арга хэмжээний судалгааг гаргаж хүргүүлсэн.

2021 оны 12 сарын 01 нд Аймгийн мал эмнэлгийн газрын МЭМА-ны дарга Сундуйгаар ахалсан ажлын хэсэг мал эмнэлгийн тасаг, хувийн мал эмнэлгүүдэд стандартын үзлэг шалгалт хийсэн. Уг шалгалтаар 5 жилд 1 удаа болдог улсын үзлэг шалгалтын өмнө урьдчилан шалгаж, шаардлагатай зүйлийг бүрдүүлэх талын зөвлөмж өгч ажилласан.

Жилийн эцсийн тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн төлөвлөгөөний хяналтын хэрэгжилт зэргийн биелэлт гаргаж аймгийн мал эмнэлгийн газар болон сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.

2021 оны 12 сарын 06 нд өрх, хүн, ам, мал тоологын симаниарт сууж 12 сарын 07 ноос эхлэн өрх, хүн ам, мал тооллогын ажлаар Дэлгэр багт 5 хоног ажилласан.

2021 оны 12 сарын 15 наас эхлэн “Улсын аварга малчин өрх” шалгаруулах болзол журмын дагуу малчдын материал бүрдүүлэх ажилд хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд, багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж 4 малчны материал бүрдүүлж сумын Засаг даргын зөвлөлд оруулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Смарт лифт ХХК-ын барьсан угаалгын ванныг хүлээн авах ажлын хэсэгт орж ажиллан, 12 сарын 27 нд хувийн мал эмнэлгүүд албан ёсоор хүлээж авахаар болсон.

2021 оны 12 сарын 16 нд хуралдсан сумын ИТХ-ын ээлжит хуралдаанаар аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны 12 сарын 15 ны өдрийн 01/51 албан тоотыг танилцуулсан. Мал эмнэлгийн арга хэмжээнд зардал тусгах саналыг иргэдээс санал авч эрэмбэнд оруулах чиглэл өгсөн.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

1.Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 5 төсөл хөтөлбөрт хамрагдсан 7 иргэдийн 15,728750 төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулж байгаа бөгөөд хугацаа хэтрэлттэй 6 иргэний 11,5 сая төгрөг төлүүлсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

1. Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж, асаргаа сунгуулах 18 иргэний материал, мөн түлээ нүүрсний хөнгөлөлтөнд 16 иргэний материалуудыг бүрэн шийдвэрлэсэн. 12 сарын хүнсний эрхийн бичгийг 33 өрхөд олгож байна . Шинээр төрсөн 2 хүүхдийн өргөдлийг хүлээн авч программд бүртгүүлсэн. Цалинтай

аав хөтөлбөрт 2 иргэн хамрагдсан. Халамжийн шугамын дагуу 10 ахмад настанд 10 хоног өдрийн үйлчилгээнд хамруулсан.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 704501,5 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -615010,1 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 71440,0 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 18051,4 мян төг орлоо.

Хэлтсээс 1365000.0 мян төгрөгийн санхүүжилт авч 455 тэтгэвэр авагчдад 1961799,8мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДДаатгалд 176 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 71440,0 мян төгрөгийн шимтгэл , Эрүүл мэндийн даатгалд 250 даатгуулагчийг даатгаж 18051,4 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн. Хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлд 450,0 мян төгрөгийн алданги тооцож оруулаад байна.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хуульд 26 иргэн хамрагдан 55146,0мян төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -36, тахир дутуугийн тэтгэвэр-5, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -2 нийт 38 тэтгэврийг тогтоож, 6 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн, 11 даатгуулагчдад ажилгүйдлын тэтгэмж тогтоон олгоод байна.

Улсын төсвөөс 36500,0 саятөгрөгийг тэтгэмжийн санхүүжилт оршуулгын тэтгэмж 23 тэтгэвэр авагчдад 23000.0 мян төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 31 даатгуулагчдад 50602,4 мян, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 35 даатгуулагчдад 5601,9 мян төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

Нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаандаа төлөөгүй 2 аж ахуй нэгжид албан шаардлага хүргүүлж 130000,0мян төгрөгийн шимтгэлийн өр авлагыг барагдуулж 130000,0мян төгрөгийн шимтгэлийн өр авлагыг барагдуулсан.

2020 оны харилцах, тооцооны хуудас тайлан, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-50 ,тэтгэвэр авах зөвшөөрөл-5, Банк солих-5 , тэтгэмж-50, ажилгүйдлын тэтгэмж-11,малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлүүлэх хуулиар -30, малчнаар ажилласан жил тогтоолгох-17 нийт 168 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж , 979 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Ерөнхий боловсролын сургууль :

- 12-р сарын 7-нд Аймгийн Боловсролын газарт 2021 оны ажлын тайланг 4 чиглэлээр бичиж хүргүүлэв.
- Сурагчдад өгч буй үдийн хоолыг батлагдсан цэсний дагуу хийж бэлтгэн эцэг эхийн төлөөлөлд амтлагаа зохион байгуулав. Нийт 10 эцэг эх оролцлоо.
- Сургуулийн номын сан, “Номын анд” клубын сурагчдаас багш ажилчдын дунд [#NoPhone](#) дуудлагыг 12 дугаар сарын 01-нээс нэг сарын хугацаатай зарлав.
- Тус сумын уугуул УБ хотод оршин суугч Б.Ууганбаяр АУБ Н.Уранбилэг багшийн урилгаар 8б ангид “Мэргэжил сонголт”, “Хувь хүний төлөвшил”, “Хувь хүний хөгжил” сэдвээр сургалт явуулав. Нийт 23 хүүхэд хамрагдав.
- Бага ангийн 10 бүлгийн сурагчдад ном уншихыг уриалах зорилгоор "Номын анд" клубын сурагчид 30 үлгэр уншиж өгөв.
- “Номын анд клуб”-ээс зохион байгуулсан ном уншиж тэмдэглэл хөтлөх "Мэдлэг дүүрэн ном" уралдаанд 2-3 р ангийн тэргүүний уншигч хүүхдээр 2б ангийн сурагч Э.Ишгэрэл, 4-5 дугаар ангийн тэргүүний уншигч хүүхдээр 5б ангийн сурагч И.Бадамхорол, 6-9р ангийн тэргүүний уншигч хүүхдээр 8б Э.Алдармаа, "УНШИГЧ АНГИ ХАМТ ОЛОН" төрөлд 2-3р ангийн "Уншигч анги хамт олон"-оор Д.Мөнхгэрэл багштай 2Б анги, 4-5р ангийн "Уншигч хамт олон"-оор Э.Баасан багштай 5Б анги, 6-9р ангийн "Уншигч хамт олон"-оор Н.Уранбилэг багштай 8Б анги шалгарав.
- Цахим орчин болон "Хувь хүний сонирхолыг хүндлэх" гэсэн сэдвүүдээр "Номын анд клуб"-ын сурагчид мэтгэлцээн зохион байгуулж санал бодлоо хуваалцлаа. Нийт 12 суралцагч оролцов.
- “Номын анд” клуб” ахмадын өдөр өнжүүлэх ажиллуулах үеэр “Ахмадаа дархлаажуулъя” өдөр ахмадуудад, амралтын өдрөөр ажилладаг сургуулийн цэвэрлэгч, галч, захиргааны галч нар, эмнэлгийн сувилагч, галч, багш нарт халуун аарц өгөв.
- Нийт багш ажилчид цас орсны дараа сумын төвийн засмал замын цас цэвэрлэв.
- "Сурагчийн зөвлөл" клубын сурагчид дархлаа дэмжих аяныг зохион байгуулж цагдаа, хийдийн галч, дотуур байрын жижүүрүүд, дэлгүүрүүдэд халуун аарц өгөв.
- Д.Мөнхжаргал багштай 4а ангийн нийт 22 хүүхдэд иргэн Г.Амаржаргал дархлааг дэмжи “Зөв” аарц, витамин өгөв.
- "Номын анд"клубын сурагчид 2а,3а,4а ангиудад номын тэмдэглэлийг хэрхэн хөтлөх, 5а ангийн сурагчдын дунд сурагчдын сурах идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор "Ухаанаараа өрсөлдье" тэмцээн зохион байгуулав.
- Сургуулийн захирал З.Эрдэнэчимэг БШУЯам, Тайландын Гүнжийн төслийн ажлын алба, төсөл хэрэгжүүлж буй 5 сургуулийн хамтарсан онлайн хуралд оролцож тайлангаа тавьлаа. Төсөл цаашид үргэлжлүүлэн хэрэгжихээр болов.
- 9а ангийн сурагч М.Эрдэнэзул, М.Ууганбаяр, Б.Төгссайхан, У.Төгөлдөр нар “Ханд” багшийн нэрэмжит физикийн олимпиадын нэгийн даваанд тэнцэж, УБ хотод болсон хоёрын даваанд амжилттай оролцлоо. Сургуулийн захирагаанаас 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

- Сумын улаан загалмайн хорооноос дотуур байрын хүүхдүүдэд Маск-300ш, Витамин С-150ш, Зөв аарц -80 ш, Витагрип-80 ш хандивлав.
- “Сүхбаатар нэг мөрөөдөл” ТББ-аас аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерүүдийн дунд зохион байгуулсан "Шилдэг илтгэлийн уралдаан"-д сургалтын менежер Д.Уугансүрэн тэргүүн байр эзэлж 5 сая төгрөгийн шагналын эзэн болов.
- БШУЯамнаас Хэнтий аймагт 12-р сарын 17-ноос 5 хоногийн зохион байгуулагдаж буй “Хүмүүжлийн эерэг арга” сургалтад СНА Т. Вера хамрагдлаа.
- Аймгийн нийтийн номын сангаас зохион байгуулсан “Судар эгшиглэн” төсөлд МХУЗ-ын багш Л.Мөнхтуяа 15 номоо уншиж тэмдэглэл хүргүүлж 12-р сарын 18-нд болсон “Судар эгшиглэн-2021” хаалтын үйл ажиллагаанд оролцож, зохиолч яруу найрагч Т.Баярхүүгийн нэрэмжит шагнал,”Судар эгшиглэн-2021” шилдэг тэмдэглэлүүд номонд “Хунгийн чуулга” уншсан номын тэмдэглэл нь багтаж шилдэг оролцогч болсон. Мөн тухайн оролцогчдын бүтээлийн үзэсгэлэнд уншсан номын тэмдэглэлүүд болон бүтээлүүд нь орсноороо онцлог байлаа.

Хүүхдийн цэцэрлэг:

- Цэцэрлэгийн амралт эхэлсэн хэдий ч 4-5 насны 41 хүүхдийг 2 бүлэгт хүлээн авч үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.
- Аймгийн “Угийн бичиг”-ийн уралдаанд нийт 17 хүний угийн бичгийн зураглал, бичиглэлийн хамт илгээж байгууллагаараа Тэргүүн байр, туслах багш Л.Сарангоо тусгай байр эзэллээ.
- Аймгийн Боловсролын газраас авдаг жилийн эцсийн тайланг БАГШИЙН ХӨГЖИЛ, СУРГАЛТЫН ЧАНАР, ШИНЭЛЭГ БҮТЭЭЛЧ АЖИЛ, ЭРҮҮЛ ЭЭЛТЭЙ ЭРСДЭЛГҮЙ ОРЧИН гэсэн 4 төрлөөр бичиж заасан хугацаанд илгээлээ.
- Халдвар хамгааллын дэглэмээ нарийн баримтлан цэвэрлэгээ үйлчилгээгээ тогтмолжуулан ажиллаж байна.
- Нэг сул ангиа “Багш хөгжлийн төв” болгон тохижууллаа.
- Аймагт зохион байгуулагдсан “Би-Залуу багш” 2 өдрийн сургалтад 1 багш хамрагдлаа.
- “Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд ном тоглоомын багцыг хөдөөгийн малчин өрхийн 15 хүүхдэд 180км тойрч хүргэж ажиллалаа.
- “Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт илтгэлийг багш нар бичиж боловсролын газарт илгээлээ.
- Ажлын байран дээр 2 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 38 багш ажилчид хамрагдлаа.
- Засмал замын хуваарьт газрын цасыг арилгаж цэвэрлэлээ.

Соёлын төв:

Тайлант хугацаанд манай байгууллага нь мэргэжлийн 5 гэрээт 2 гэсэн нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Долоо хоногийн 1 дэх өдөр болгон ард иргэд, албан байгууллага, аж ахуй нэгж ,залуучууд,ахмадуудад ,нийтийн

цэнгээнт бүжиг зохион байгуулан явуулж байна.Шинэ соёлын төвдөө нүүж орон тохижуулах ажилаа эрчимтэй явуулж байна.

Соёл бол Гоёл хандивын аяны уриалга гарган ард иргэд албан байгууллагууд идэвхтэй хамрагдаж байна.”Угийн бичгээ хөтөлж Удмын сангаа хамгаалъя ” уралдаанд сумандаа шалгарсан уулбаян сумын цэцэрлэгийн хамт олон аймгийн угийн бичгийн уралдаанд тэргүүн байр эзэлж бахдам сайхан амжилттай оролцлоо.Түвшинширээ сумын соёлын төврүү очиж туршлага судлалаа.2021 оны 12.11 нд Соёлын дэд сайд М.Батбаяраар ахлуулсан ажлын хэсэг сүхбаатар аймагт ирж соёлын төвийн дарга нар болон бусад албан хаагчидтай сургалт уулзалт зохион байгуулж ажилалаа.Дэд сайдад соёлын төвд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа болон албан бичгээ хавсралтаар хүргүүлсэн. Мөн аймгийн орлогч дарга Шижирбаатарт албан бичгээ хавсралтаар хүргүүлсэн. Номын сан нь тайлант хугацаанд 12 иргэнд карт шинээр нээж 21 номыг гэрээр олгох үйлчилгээ үзүүлсэн.

Цахим хуудсаараа дамжуулан танин мэдэхүйн мэдээлэл 3 оруулж :529 хүний хандалт авсан байна.Мөн зохиолч Д.Мөнхбаатарын зохиол “Нүүдлийн хөх тойрог” туужийг цувралаар уншигчдадаа хүргэж байна. Нийтдээ 1800 гаруй хүний хандалт авсан. Аймгийн нийтийн номын сангаас зарласан “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах уралдаанд уншигч хүүхдүүдээ бэлтгэж байна.шинэ соёлын төвийн барилга ашиглалтанд орох гэж байгаатай холбогдуулан шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл эд хөрөнгийн судалгааг гаргаж Соёлын яаманд хүсэлт хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн Газрын 257 тогтоол аймаг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын хэмжээнд угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлэх зорилгоор ЗДТГ-тай хамтран “УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ -УДМЫН САНГАА ХАМГААЛЪЯ” сэдэвт угийн бичиг хөтлөх уралдааныг албан байгууллага ард иргэдийн дунд зарлаад байна.

Мөн “Угийн бичиг хөтлөх аргачлал” сургалтыг зохион байгуулж байна.Хүүхдийн цэцэрлэгийн хамт олонд ажлын байран дээр нь очиж сургалтыг нийт ажилчдад онолын болон практик хэлбэрээр зохион байгууллаа.

Эрүүл мэндийн төв:

2021 оны 12 дугаар сарын 27 ны үзлэгийн мэдээ

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1886
2	Амбулаторийн үзлэг	1548
3	Идэвхтэй хяналт	110
4	Гэрийн эргэлт	110

5	Гэрийн дудлага	260
6	Алсын дуудлага	129
7	Артерийн даралт чихрийн шижингийн үзлэг	759
8	Хөхний үзлэг	903
9	Эсийн шинжилгээ	143
10	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	262
11	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	I тун- 4722 II тун-1865 III тунд -868/52%, 2-11 насны томуугийн эсрэг вакцинд -250 хамрагдаад байна.
12	Түргэвчилсэн тест	1085
13	ПГУ шинжилгээ	327

Хууль, эрх зүйн чиглэлээр:

ЗДТГ-ын Дотоод хяналт шалгалтын багаас батлагдсан удирдамжийн дагуу 2021 оны 12 дугаар сарын 06, 21-ны өдрүүдэд 2 удаагийн төлөвлөгөөт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар байгууллагын удирдлагад шаардлага хүргүүлсэн.

Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны талаарх хийсэн ажлын жилийн эцсийн тайланг аймгийн Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас 2021 оны 12 дугаар 23-ны өдөр Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэгийг шинэчлэн гаргуулахтай холбоотой бэлтгэлийг хангуулах зорилгоор мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан сургалтад ЭБАТ хамрагдсан.

Иргэдээс ирүүлэх өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг хүлээн авах 98514040 дугаар ажиллаж байна. 12 дугаар сард гэмт хэрэг-2, зөрчил-4 тус тус бүртгэгдсэн байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ